ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас нуур -Завхан голын сав газрын захиргааны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/203/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга........8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан........13

4.1 Ерөнхий зүйл ........13

4.2 Материаллаг байдал ........14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт........14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........16

5. Аудитын илрүүлэлт ........16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.01.27 № 30

танай ______ -ны № ______ -т

ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Э.ЗОЛ-ОД-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгуЗуллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа нь 2024 онд 85,776.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээ хийлгэхээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэнээс автотээврийн хэрэгслийн үнэ өөрчлөгдөөгүй, ашиглах хугацааг бууруулж, бусад хөрөнгийг дахин үнэлж, ашиглагдах хугацааг шинэчлэн тогтоосоныг данс бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Усны газраас Яруу сумын Хаг нуурыг сэргээн засварлах 15,000.0 мянган төгрөгийн өртөгтэй ажлыг санхүүжүүлсэн бөгөөд ажлыг гэрээний дагуу бүрэн гүйцэтгэж, ажлын хэсэг хүлээн авсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

D/disk/Албан бичиг/Дүгнэлт-2025

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *|төгрөгөөр|*

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Байгууллагын нэр: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 12,229,490.00 | 6,180,569.49 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | | |
| 311 | Кассанд байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | |
| 314 | Замд яваа мөнгөн хөрөнгө | | |
| 33 | АВЛАГА | | 149,456.15 |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 49,456.15 |
| 335 | Бусад авлага | | 100,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 100,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 12,229,490.00 | 6,031,113.34 |
| 351 | Түүхий эд материал | 1,425,000.00 | 202,500.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 1,425,000.00 | 202,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 10,804,490.00 | 5,828,613.34 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 962,620.00 | 316,500.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 1,369,990.00 | 95,500.00 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 3,922,900.00 | |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 2,845,580.00 | 5,416,613.34 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 1,703,400.00 | |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 339,497,710.44 | 438,606,670.67 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 339,497,710.44 | 438,606,670.67 |
| 392 | Биет хөрөнгө | 339,497,710.44 | 437,338,737.34 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 398,326,336.50 | 398,326,336.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -105,125,277.55 | -47,011,680.11 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 60,708,064.09 | 84,289,320.24 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -21,497,108.53 | -7,274,206.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,118,349.09 | 13,262,921.59 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,032,653.16 | -4,253,954.08 |
| 393 | Биет бус хөрөнгө | | 1,267,933.33 |
| 39301 | Програм хангамж | 700,000.00 | 1,267,933.33 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -700,000.00 | |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 351,727,200.44 | 444,787,240.16 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 100,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | 100,000.00 |
| 413 | Өглөг | | 100,000.00 |
| 4136 | Бусад өглөг | | 100,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | 100,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 414 | Урьдчилж орсон орлого | | |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | | |
| 422 | Урт хугацаат зээл | | |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 351,727,200.44 | 444,687,240.16 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 351,727,200.44 | 444,687,240.16 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | | |
| 51101 | Өмч: - төрийн | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 351,727,200.44 | 444,687,240.16 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 351,727,200.44 | 351,727,200.44 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 92,960,039.72 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 351,727,200.44 | 444,787,240.16 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *//төгрөгөөр/*

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 598,872,741.57 | 544,636,718.33 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 280,532,641.57 | 108,272,983.33 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 280,532,641.57 | 108,272,983.33 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 280,532,641.57 | 108,070,483.33 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 202,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 318,340,100.00 | 436,363,735.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 307,010,100.00 | 402,077,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 307,010,100.00 | 402,077,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,330,000.00 | 34,286,635.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,000,000.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,430,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.00 | 28,596,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 100,000.00 | 5,689,935.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | | |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 307,342,453.97 | 451,676,678.61 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 307,342,453.97 | 451,676,678.61 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 278,777,233.84 | 424,242,315.86 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 178,441,889.22 | 266,038,912.40 |
| 210101 | Үндсэн цалин | 111,987,932.31 | 158,091,656.81 |
| 210102 | Нэмэгдэл | 34,890,448.37 | 50,664,355.59 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,577,600.00 | 35,549,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,985,908.54 | 21,733,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,308,346.91 | 32,927,144.91 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,177,760.58 | 22,441,360.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,785,618.94 | 2,611,516.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,428,495.07 | 1,330,508.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,599.83 | 1,308,751.49 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,565,872.49 | 5,235,008.25 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,145,090.00 | 16,283,721.66 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,954,640.00 | 3,725,670.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,049,320.00 | 9,668,401.66 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,105,170.00 | 1,206,550.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 668,480.00 | 1,259,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,367,480.00 | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | 424,000.00 |
| 2105 | Нормативт зардал | | 1,061,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | | 1,061,250.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 619,900.00 | 8,519,550.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 6,934,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 619,900.00 | 1,585,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,539,410.00 | 29,468,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,539,410.00 | 29,468,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,438,073.04 | 53,571,723.79 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,690,354.04 | 50,886,224.79 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 756,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,326,425.00 | 1,433,275.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 527,594.00 | 303,724.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 103,700.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 93,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,284,524.67 | 16,371,413.10 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 3,795,890.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,147,100.00 | 3,614,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,137,424.67 | 8,961,523.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,565,220.13 | 27,434,362.75 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 100,000.00 | 18,417,300.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 5,599,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 12,817,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 28,465,220.13 | 9,017,062.75 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,465,220.13 | 9,017,062.75 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 291,530,287.60 | 92,960,039.72 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | |

| | | | |
|---|---|---|---|
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | | |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 291,530,287.60 | 92,960,039.72 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Байгууллагын нэр: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 318,340,100.00 | 436,363,735.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 318,340,100.00 | 436,363,735.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 307,010,100.00 | 402,077,100.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 307,010,100.00 | 402,077,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,330,000.00 | 34,286,635.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 2,000,000.00 | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,430,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 800,000.00 | 28,596,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 100,000.00 | 5,689,935.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 295,340,100.00 | 436,363,735.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 295,340,100.00 | 436,363,735.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 266,774,879.87 | 408,929,372.25 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 179,114,470.62 | 266,038,912.40 |
| 210101 | Үндсэн цалин | 112,906,723.56 | 145,208,244.43 |
| 210102 | Нэмэгдэл | 34,806,338.52 | 63,547,767.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,415,500.00 | 35,549,000.00 |
| 210104 | Урамшуулал | 20,985,908.54 | 21,733,900.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 22,308,353.85 | 32,976,601.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,177,760.58 | 22,441,360.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,785,618.94 | 2,674,216.12 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,428,495.07 | 1,330,508.07 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 350,599.83 | 1,295,507.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,565,879.43 | 5,235,008.25 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,999,330.00 | 16,483,735.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,289,900.00 | 1,680,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,594,900.00 | 12,239,435.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,105,170.00 | 1,206,550.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 480,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,529,360.00 | 1,357,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 600,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,349,900.00 | 4,821,550.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,349,900.00 | 4,821,550.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 16,539,410.00 | 29,468,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 16,539,410.00 | 29,468,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,406,315.40 | 53,727,723.79 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 20,630,356.40 | 50,886,224.79 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 756,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,326,425.00 | 1,433,275.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 555,834.00 | 303,724.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 103,700.00 | 99,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 249,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,457,100.00 | 5,412,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,457,100.00 | 5,412,250.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 28,565,220.13 | 27,434,362.75 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 100,000.00 | 18,417,300.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 5,599,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 12,817,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 28,465,220.13 | 9,017,062.75 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,465,220.13 | 9,017,062.75 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 23,000,000.00 | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 23,000,000.00 | |
| | Дотоод эх үүсвэрээр | 23,000,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,000,000.00 | |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -23,000,000.00 | |

**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

Байгууллагын нэр: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | 60,196,912.84 | 60,196,912.84 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 7 | Тайлант үеийн үр дүн | | | 291,530,287.60 | 291,530,287.60 |
| 10 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | 351,727,200.44 | 351,727,200.44 |
| 11 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 17 | Тайлант үеийн үр дүн | | | 92,960,039.72 | 92,960,039.72 |
| 18 | ................ | | | | |
| 19 | 20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | 444,687,240.16 | 444,687,240.16 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *_/төгрөгөөр/_*

# ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа

Тайлант хугацаа: 2024.12.31

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харьцуулалт |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 402,077,100.00 | 402,077,100.00 | | 100 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 402,077,100.00 | 402,077,100.00 | | 100 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 389,259,700.00 | 380,542,637.25 | 8,717,062.75 | 97.76 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 271,451,700.00 | 266,038,912.40 | 5,412,787.60 | 98.01 |
| 210101 | Үндсэн цалин | 145,195,000.00 | 145,208,244.43 | -13,244.43 | 100.01 |
| 210102 | Нэмэгдэл | 68,882,200.00 | 63,547,767.97 | 5,334,432.03 | 92.26 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 35,610,300.00 | 35,549,000.00 | 61,300.00 | 99.83 |
| 210104 | Урамшуулал | 21,764,200.00 | 21,733,900.00 | 30,300.00 | 99.86 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,931,300.00 | 32,976,601.06 | 954,698.94 | 97.19 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,073,400.00 | 22,441,360.98 | 632,039.02 | 97.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,714,500.00 | 2,674,216.12 | 40,283.88 | 98.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,359,300.00 | 1,330,508.07 | 28,791.93 | 97.88 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,355,100.00 | 1,295,507.64 | 59,592.36 | 95.6 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,429,000.00 | 5,235,008.25 | 193,991.75 | 96.43 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | | | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 12,252,800.00 | 12,173,700.00 | 79,100.00 | 99.35 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,539,900.00 | 1,539,650.00 | 250 | 99.98 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,468,400.00 | 8,468,400.00 | | 100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,284,500.00 | 1,206,550.00 | 77,950.00 | 93.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,000.00 | 959,100.00 | 900 | 99.91 |
| 2105 | Нормативт зардал | | | | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,825,500.00 | 4,821,550.00 | 3,950.00 | 99.92 |
| 210604 | Урсгал засвар | 4,825,500.00 | 4,821,550.00 | 3,950.00 | 99.92 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 20,391,900.00 | 20,391,900.00 | | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,391,900.00 | 20,391,900.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,993,500.00 | 38,727,723.79 | 2,265,776.21 | 94.47 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,998,000.00 | 35,886,224.79 | 111,775.21 | 99.69 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 756,000.00 | 756,000.00 | | 100 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 3,220,800.00 | 1,433,275.00 | 1,787,525.00 | 44.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 518,600.00 | 303,724.00 | 214,876.00 | 58.57 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 250,100.00 | 99,000.00 | 151,100.00 | 39.58 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 250,000.00 | 249,500.00 | 500 | 99.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,413,000.00 | 5,412,250.00 | 750 | 99.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,413,000.00 | 5,412,250.00 | 750 | 99.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 12,817,400.00 | 21,534,462.75 | -8,717,062.75 | 168.01 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 12,817,400.00 | 12,817,400.00 | | 100 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,817,400.00 | 12,817,400.00 | | 100 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 8,717,062.75 | -8,717,062.75 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 8,717,062.75 | -8,717,062.75 | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 34,286,635.00 | -34,286,635.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 34,286,635.00 | -34,286,635.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 28,596,700.00 | -28,596,700.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,689,935.00 | -5,689,935.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны чиглэл:***

Сав газарт усны нөөцийн зохистой ашиглах, хамгаалах тогтвортой менежментийг хэрэгжүүлэх

**Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны зорилго*:** Усны нөөцийн төрөл бүрийн ашиглалт, хэрэглээ тэдгээрээс учруулах сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг нэгтгэн сонирхогч талуудын оролцоотойгоор оновчтой нэгдсэн бодлого, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх замаар сав газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад оршино. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 14 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 89.3 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Байгаль орчин тухай хууль
2. Усны тухай хуул хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай  хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
10. Хөдөлмөрийн тухай хууль
11. Төрийн хэмнэлтийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дот оод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан  төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 93,060.0 мянган төгрөгөөр буюу 26.4 хувиар өссөн байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | | 149.4 | 149.4 |
| Бараа материал | 12,229.4 | 6,031.1 | -6190.3 |
| Үндсэн хөрөнгө | 339,497.7 | 438,606.6 | 99,108.9 |
| **Нийт хөрөнгө** | **351,727.2** | **444,787.2** | **93,060.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 351,727.2 | 444,687.2 | 93,060.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **351,727.2** | **444,787.2** | **93,060.0** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Авлагын эхний үлдэгдэл байхгүй, тайлант онд үүссэн авлагаас эцсийн үлдэгдэл 149.4 мянган төгрөг болсон байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 12,229.4 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 22,052,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Сав газраас 202.53 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 28,453.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 60,031.1мянган төгрөг болж, өмнөх оноос 6,190.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор 108,070,4 мянган төгрөгийн хөрөнгө дахин үнэлэгдсэн үнээр бүртгэгдсэн, хандиваар 22,200.0 мянган төгрөгийн хөрөнгө, 11,336.2 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 2,274,2 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, 83,502.4 мянган төгрөгийн хөрөнгө элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж дахин үнэлэгдэн хасагдаж ,жилийн эцэст 444,687.2 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 8,961.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 444,787.2 мянган төгрөг нь тайлант онд өөрчлалт ороогүй болно.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 402,077.1 мянган төгрөг, нийт зарлагыг 402,077.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 800,413.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 393,360.0мянган төгрөг буюу 97.8 хувьтай байна. Энэ нь цалин,НДШ-ийн зардал 6,367.5 мянган төгрөгөөр, шуудан холбоо, бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардал 2,349.5 мянган тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| | **Усны нөөц, нуур, гол мөрний менежмент** | | | | |
| **71404** | Үндсэн үйл ажиллагааны зардал | 395148.3 | 386243.1 | 8905.2 | 97.7% |
| 80101 | Харуул хамгаалалтын зардал | 28398.0 | 28286.3 | 111.7 | 99.6% |
| 80219 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 12817.4 | 12817.4 | - | 100% |
| 80802 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 395148.3 | 386243.1 | 8905.2 | 97.7% |
| **НИЙТ** | | **436363.7** | **427346.8** | **9017.0** | **97.9%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 34,286.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, Яруу сумын Хаг нуурыг сэргээх сувгийн цэвэрлэгээний ажилд 15000,0 мянган төгрөгийг, урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах ажилд 3,485.7 мянган төгрөгийг, булгийн эхийг хашиж хамгаалсан ажилд хянан баталгаажуулалт хийх, хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгаа гаргах ажилд 6,904.1 мянган төгрөгийг зарцуулж, 8,896.8 мянган төгрөгийг усны газрын давсан орлогоос ажилчин албан хаагчидад нэг удаагийн тэтгэмж, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах/БОУАӨЯ/ | Яруу сумын Хаг нуурыг сэргээх сувгийн цэвэрлэгээний ажил | 15,000,000 | 15,000,000 |
| 2 | Шууд гэрээгээр/Дэлхийн байгаль хамгаалах сан/ | Урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах | 3,485,790 | 3,485,790 |
| 3 | Шууд гэрээгээр/Гранд авгуш/ | Булгийн эхийг хашиж хамгаалсан ажилд хянан баталгаажуулалт хийх | 1,904,145 | 1,904,145 |
| 4 | Шууд гэрээгээр/Усны газар/ | Хөв цөөрөм байгуулах боломжит газрын судалгаа гаргах | 5,000,000 | 5,000,000 |
| **ДҮН** | | | **25,389,935** | **25,389,935** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 544,636.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,399.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,549.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 544,636.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,399.3 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,549.5 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа*ны* 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж Хагнуурын хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаагүй, ажлыг дуусгаж хүлээж авсан акт, баримтыг бүрдүүлэх 7500,0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж, үзвэрийн билетний үнийг төсвөөс төлсөн 100,0 мянган төгрөгийг байгууллагын дансанд төвлрүүлэх төлбөрийн акт тогтоогдож хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын хөдөлгөөний бичилтийг зөв хийх, зардлын эдийн засгийн ангиллаар зөв зарцуулах 2 зөвлөмж, 1,508.3 мянган төгрөгийн зөрчилдтөлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 1,508,330- | 1 | 1,508,330 | 100% |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | 100% |
| **Нийт дүн** | 3 | 1,508,330 | 3 | 1,508,330 | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,165.2 мянган төгрөгийн алдаа илэрч 4,565.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7500,0 мянган төгрөгийн алдаанд зөвлөмж өгч, 100,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон залруулж болон аудитын явцад бүрэн хэрэгжилтийг хангуулсан.

***Залруулсан алдаа:***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 792 дугаар тогтоолоор акталсан 3000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд дутуу тусгасан, Даатгалын үйлчилгээний 1365775 мянган төгрөгийг бараа материалын тодруулгад бүртгэсэн, үнэ төлбөргүй ирсэн 202500 төгрөгийн тусгай зориуллатын материалыг төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар бүртгэсэн зэрэг бичилтийн алдаа гарсан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/ 229 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" ,Сангийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Ангилал шинэчлэн батлах тухай" А/211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн орлого ,зарлагын эдийн засгийн ангилал, Санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалт," -тай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** залруулж тайлан гаргасан

### 5.1 Төлбөрийн акт :

Үзвэрийн билетийн 100,0 мянган төгрөгийг үнийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 15.1.4.-д "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх " гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** завсрын аудитаар холбогдох ажилтнуудаас суудган тооцож байгууллагын дансанд төвлөрүүлсэн

### 5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

### 5.3 Зөвлөмж

Хаг нуурын хөтөлбөр арга хэмжээний 7500,0 мянган төгрөгийн ажлын хэрэгжилтийг тайлагнаагүй,ажлын гүйэтгэл, хүлээж авсан актуудыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах"; гэж заасантай нийцэхгүй, толилуулга, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Завсрын аудитын явцад хэрэгжилтийг хангуулан ирүүлсэн

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн илэрч 4,565.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 30-ны 792 дугаар тогтоолоор акталсан 3000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд дутуу тусгасан | 1 | 3,000,000 | 1 | 3000,000 | | | 1 | 3000,000 | | | | |
| Даатгалын үйлчилгээний 1365775 мянган төгрөгийг бараа материалын тодруулгад бүртгэсэн, үнэ төлбөргүй ирсэн 202500 төгрөгийн тусгай зориулалтын материалыг төсвийн хөрөнгөөр худалдаж авснаар бүртгэсэн | 2 | ,1568,275 | | | 2 | 1,568,275 | 2 | 1,568,275 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **4,568,275** | **1** | **3,000,000** | **2** | **1,568,275** | **3** | **4,568,275** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хаг нуурын хөтөлбөр арга хэмжээний 7500,0 мянган төгрөгийн ажлын хэрэгжилтийг тайлагнаагүй,ажлын гүйэтгэл, хүлээж авсан актуудыг санхүүгийн баримтад хавсаргаагүй | 1 | 7,500,000 | | | | | 1 | 7,500,000 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үзвэрийн билетийн 100,0 мянган төгрөгийг үнийг төсвөөс төлсөн нь | 1 | 100,000 | 1 | 100,000 | | | | | | | | |
| **Дүн** | **2** | **7,600,000** | **1** | **100,000** | | | **1** | **7,500,000** | | | | |

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-14

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМО АУДИТ” ХХК АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-14